

Шинэчилсэн найруулга 2012 он

БАТЛАВ: ТУЗ-ийн дарга

С. ПУРЭВ.



УЛСЫН БҮРТГЭЛИЙН БОТЛАГЧ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС
ТТС2513 33/1-02

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн
дугаар 1010001006

2012 оны 04 дугаар сарын 30-ны өдөр
"ХАРХОРИН" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ
БҮРТГЭЭЛ, УЛСЫН БҮРТГЭГЧИЙН
ЭЗЛЖИТ ХУРЛААР ШИНЭЧЛЭН БАТЛАВ.

"ХАРХОРИН" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын Иргэний хууль, Компанин тухай хууль, бусад холбогдох хууль болон энэхүү дүрмээр компанин үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. Компани нь нээлттэй, хувьцаат компани болно.
- 1.3. Компанин оноосон нэр нь:
монголоор "Хархорин" ХК
англиар: KHARAKHORUM CO.JSC
Байршил нь : Өвөрхангай, Хархорин, Эрдэнэ толгой, Усжуулахын контор
Хаяг нь: утас: 70327890 ,70150420 факс: 70327890
- 1.4. Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо: 539,515 ширхэг
энгийн хувьцаа
Нэрлэсэн үнэ: 100 төг
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:

ХОЁР. Үйл ажиллагааны зорилго, чиглэл

2.1. Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулах, ажиллагсдын нийгмийн болон ахуйн хэрэгцээг бүрэн дүүрэн хангах, хамт олны дотор нөхөрсөг уур амьсгал бүрдүүлж ажиллах замаар ашгийн хэмжээг нэмэгдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдлэх, нийгмийн ашиг тусын тулд ажиллах нь компанийн эрхэм зорилго юм.

2.2. Компанийн үйл ажиллагааны чиглэл:

- Газар тариалан
- Жимс, жимсгэнийн аж ахуй
- Мал аж ахуйн үйлдвэрлэл
- Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл
- Гурилын үйлдвэрлэл
- Худалдаа, үйлчилгээ
- Аялал, жуулчлал
- Хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа

Шинэчилсэн найруулга 2012 он

2.3. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

2.4. Компани нь өөрийн салбар эсвэл төлөөлөгчийн газрыг бусад аймаг, хот, сум, дүүрэг, хороонд ажиллуулна. Үүнийгээ хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлнэ.

2.5. Компани нь тодорхой мэргэшил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаандаа холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авсны дараа улсын бүртгэлд бүртгүүлж, тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

ГУРАВ. Компанийн үндсэн эрх

3.1. Компани нь өөртөө барааны тэмдэг болон бэлэгдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ. Бэлэгдэл, барааны тэмдгийг Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн компани эдлэнэ.

3.2. Компани өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар болон бусадтай хамтран Монгол улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.

3.3. Компани өөрийн үйл ажиллагаагаа өргөтгөх, үйлчлүүлэгчдийн болон зах зээлдээ ойртох зэрэг зорилгоор улс дотроо болон гадаадад салбар, төлөөлөгчийн газар, хараат болон охин компани ажиллуулна.

3.4. Компанийн үндсэн ба туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ажлыг хэвийн явуулах зорилгоор мэргэжил чадвар сайтай дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдний ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

3.5. Компани нь өөрийн ашиг сонирхлын үүднээс байгууллага түүнчлэн олон улсын холбогдох байгууллагад гишүүнээр элсэн ажиллана.

3.6. Компани өөрийн үйл ажиллагаа, өрсөлдөх чадвартай холбоотой зарим зүйлийг хуулийн дагуу нууцлана.

3.7. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдох мэдээлэл цуглуулах, мөн ийм мэдээллийг үйлчлүүлэгч сонирхогчдод хүргэнэ.

ДӨРӨВ. Компанийн үндсэн үүрэг

4.1. Компани нь энэхүү дүрмийн 2.2-д заасан үйл ажиллагааг Монгол улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.

Шинэчилсэн найруулга 2012 он

- 4.2. Компани нь Монгол улсын "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль, "Аудитын тухай" хуулийн дагуу нягтлан бодохын болон анхан шатны, дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөн санхүүгийн тайлан тэнцэл гарган баталгаажуулна.
- 4.3. Компани нь Монгол улсын албан татварын хуулиудын заалтыг хатуу мөрдөн татвараа өөрөө тодорхойлж сайн дураар төлнө.
- 4.4. Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ мэдээллийг цаг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.
- 4.5. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын өмнө хуулиар хүлээсэн үүргүүдийг биелүүлнэ.
- 4.6. Компани нь улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд бололцооны хэрээр дэмжлэг туслалцаа үзүүлэн Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу байгаль орчныг хамгаалж ажиллана.
- 4.7. Компани нь улсын бүртгэлд бүртгүүлж үйл ажиллагаагаа явуулна.

ТАВ. Компанийн үндсэн хариуцлага

- 5.1. Компани нь зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.
- 5.2. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын эрхийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.
- 5.3. Монгол улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.
- 5.4. Компанийн Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нар нь гэрээнд заагдсан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд тэдгээр нь өөрийн хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хариуцна.
- 5.5. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд "Компаний тухай" хуулийн 84 дүгээр зүйлд заасан үүргийг биелүүлж ажиллах үүрэгтэй бөгөөд зөрчсөн тохиолдолд 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ЗУРГАА. Хувьцаа эзэмшигчийн эрх

- 6.1. Компанийн энгийн хувьцааг худалдан авч эзэмшсэн этгээд компанид хувьцаа эзэмшигч болно.
- 6.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах үед ТУЗ-өөс тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг хурал зарласан этгээдэд хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигч нь хуралд оролцож бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгнө.

Шинэчилсэн найруулга 2012 он

6.3. ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль, журамд заасан хугацаандаа олгохгүй бол алданги төлөхийг шаардаж болно.

6.4. Компанийг татан буулгах үед "Компанийн тухай" хуулийн 28-р зүйлд тогтоосон журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь тэнцүү хүртэнэ.

6.5. Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авна.

6.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас доорхи асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компани эргүүлэн авахыг шаардах эрх эдлэнэ.

6.6.1. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон ХХК болгож өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;

6.6.2. Хэлцэл хийхийн өмнөх сүүлчийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн.

6.6.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийг шинэчилсэн найруулгыг баталсан.

6.7. Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардаж болно.

6.8. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа этгээд нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон ТУЗ, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх саналаа ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор ТУЗ эсхүл гүйцэтгэх удирдлагад гаргаж болно.

6.9. Хувьцаа эзэмшигч нь "Компанийн тухай" хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэгт заасан мэдээлэлтэй танилцана.

Шинэчилсэн найруулга 2012 он

6.10. Компанийн энгийн хувьцааны нэг буюу түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтны буруугаар компани болон өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрх эдлэнэ.

6.11. Энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх эрх эдлэнэ.

ДОЛОО. Хувьцаа эзэмшигчийн үүрэг.

7.1. Компанийн дүрмийн заалтыг хэлбэрэлтгүй сахина.

7.2. Компанийн үйл ажиллагаанд бололцоотой бүх талын дэмжлэг үзүүлнэ.

7.3. Компанийн хувьцааг давуу эрхээр худалдан авах тухай саналаа хувьцааг худалдах шийдвэр гарснаас хойш ажлын 30 хоногийн дотор ирүүлнэ.

7.4. Компанийн нууцыг чандлан хадгална.

7.5. Хувьцаа эзэмшигчдийн хоорондын харилцаанд чин шударга хандана.

7.6. Компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол эрхэлсэн ажлаа үлгэр жишээ биелүүлнэ.

7.7. Хувьцаа эзэмшигч өөрийн буруугаар компанид учруулсан хохиролыг бүрэн хариуцаж төлнө. Хохирол төлүүлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор төлбөрийг компанид төлнө.

7.8. Хувьцаа эзэмшигч төлбөр төлөхөөс татгалзсан буюу зайлсхийсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр түүний ногдох хувь буюу тухайн жилд олгогдвол зохих ногдол ашгийн хэмжээг төлбөрийн дүнгийн хэмжээгээр хасч болно. Ийм боломжгүй тохиолдолд төлбөрийг шүүхийн журмаар шийдвэрлэнэ.

7.9. Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны гуравны нэг хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь уг хяналтын багцыг худалдан авсан өдрөөс хойш ажлын 60 хоногийн дотор багтаан бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал болгоно. Энэ саналыг хуульд заасан журмын дагуу гаргаагүй бол уг этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрх эдлэхгүй.

Шинэчилсэн найруулга 2012 он

7.10. Компанийн энгийн хувьцааны гуравны нэгээс дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан буюу эзэмшиж байгаа этгээд нь энэ хэмжээний хувьцааг худалдан авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор өөрийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, тус бүрийн эзэмшлийн хувьцааны тоо зэргийн талаарх мэдэгдлийг компани болон Санхүүгийн зохицуулах хороонд бичгээр хүргүүлнэ.

7.11. Компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшсэн этгээд ийнхүү өмчлөх эрх үүссэнээс хойш 3 хоногийн дотор компанид бичгээр мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдэл ирүүлэх нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд асуудал хэлэлцүүлэхээр оруулах хуульд заасан эрхээ эдлэх баталгаа болно.

НАЙМ. Хувьцаа эзэмшигчдэд хориглох зүйл, хүлээх хариуцлага

8.1. Компанийн нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглахыг хориглоно.

8.2. Компанийн нэр хүнд, өмч хөрөнгөнд гэм хор учруулж болзошгүй ямарваа үйлдэл хийхийг хориглоно.

8.3. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

8.4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, эсхүл эрх бүхий албан тушаалтан болсон хувьцаа эзэмшигч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.

ЕС. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа, бусад үнэт цаас,

түүнийг гаргах, худалдах болон эргүүлэн авах

9.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө хувьцаанд хуваагдсан байх бөгөөд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 539,515 ширхэг энгийн хувьцаа байна.

9.2. Компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн 100 төгрөгийн үнэтэй 539,515 ширхэг энгийн хувьцаа байна. Энэхүү зарласан хувьцаан дээр үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх, шинэчлэх, хэмэгдэл хөрөнгийн эх үүсвэр бий болгох зорилгоор хувьцаа нэмж гаргах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

9.3. Нэмж гаргасан хувьцааг компанийн хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдаж авах давуу эрхтэй. Энэ давуу эрхийг "Компанийн тухай" хуулийн 38-р

Шинэчилсэн найруулга 2012 он

зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлэх үүргийг Төлөөлөн удирдах зөвлөл хүлээнэ.

9.4. Компани давуу эрхийн хувьцаа гаргаж болно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх зэргийг тухай бүр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

9.5. Гаргасан хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч болох эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

9.6. Үйл ажиллагааны зарим чиглэлээр охин компани байгуулан, дүрмийн сангаа тэр хэмжээгээр хорогдуулж болно.

9.7. Компанид шинээр хувь нийлүүлэн оруулсан хөрөнгийн бүртгэл, жагсаалтыг улсын бүртгэлийн материалд тухай бүр оруулж байна.

9.8. Энэхүү хөрөнгөнд тухайлбал, үл хөдлөх хөрөнгийн хувьд үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийг гэрчилгээ, хөдлөх хөрөнгөнд хөндлөнгийн байгууллага буюу хөрөнгийн үнэлгээний компанийн тайланг хавсаргаж баталгаажуулна.

9.9. Компани гаргасан энгийн хувьцаанаас гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргаж болно.

9.10. Компани зарласан хувьцаанаас гүйлгээнд нэмж гаргах, бусад үнэт цаас гаргах шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Үнэт цаас гаргах тухай шийдвэрт гаргах үнэт цаасны төрөл, тоо ширхэг, нэрлэсэн үнэ, үнийн дүн, үнэт цаас гаргагч төвлөрүүлсэн хөрөнгийн зориулалт, үнэт цаасыг нийтэд эсхүл хаалттай захиалгаар худалдах, энгийн хувьцаанаас бусад үнэт цаас нь энгийн хувьцаанд хөрвөх эсэх, хөрвөх бол хөрвөх нөхцөл зэргийг заасан байна.

9.11. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн бол Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу бүртгүүлэх, хөрөнгийн биржид бүртгүүлэх, нийтэд сурталчлах андеррайтер болон зуучлах үнэт цаасны компанитай гэрээ байгуулан ажиллах асуудлыг гүйцэтгэх захирал хариуцан зохион байгуулна.

9.12. Компанийн зарласан хувьцаанаас Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр гүйлгээнд нэмж гаргасан үед, хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх олгохын тулд хувьцаа худалдаж авах эрхийн бичгийг гаргана. Хувьцаа эзэмшигчид хувьцаа худалдах авах давуу эрхийг гэрчлэх эрхийн бичгээ бүрэн болон хэсэгчлэн худалдаж болно. Хувьцаа худалдаж авах

Шинэчилсэн найруулга 2012 он

- 9.19. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно. Компани энгийн хувьцаанаас бусад цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдаж авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дундажаас 25 хувиас илүүгүй байна.
- 9.20. Хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн худалдах эрхийг хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эргүүлэн авах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хуралд оролцогчдын дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 9.21. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдаж авах шийдвэрийг 6.6-д зааснаас бусад тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл гаргах бөгөөд уг шийдвэртээ худалдаж авах үнэт цаасны төрөл, тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заасан.
- 9.22. Компани дараах нөхцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн авах шийдвэр гаргаж болно.
- 9.22.1. Эргүүлэн авах үүрэг бүхий энгийн хувьцааг эргүүлэн авсан
- 9.22.2. Үнэт цаасаа эргүүлэн авсны дараа төлбөрийн чадвартай байх
- 9.22.3. Компанийн өөрийн хөрөнгө нь гаргасан давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээ зэргийн нийлбэрээс илүү байх

АРАВ. Компанийн удирдлага, түүний эрх хэмжээ

А. Хувьцаа эзэмшигчдийн хурал

10.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

10.2. Нэг хувьцаа эзэмшигчтэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигч өөрөө хэрэгжүүлнэ.

10.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

10.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна.

10.5. Энэ дүрмийн 10.4-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх

Шинэчилсэн найруулга 2012 он

удирдлага/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно. Энэ тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, хуралдуулах зардлыг компани гаргана.

10.6.Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс хойш байгуулсан гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

10.7.Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ энэ хуулийн 10.4-т заасан хугацааны дотор хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргаагүй бол Санхүүгийн зохицуулах хороо тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдуулахаас бусад бүрэн эрх нь дуусгавар болсныг нийтэд мэдээлнэ.

10.8. Компанийн тухай хуулийн 60.1-д заасан эрх бүхий этгээдээс зарласан хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл хангахад компанийн удирдлага болон эрх бүхий албан тушаалтан дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээ, мэдээллээр шуурхай хангах үүрэгтэй.

10.9.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдсон зардлыг компани бүрэн хариуцна.

10.10.Хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдах этгээдийг тухайн хурлыг зарласан этгээд хурал хуралдуулах шийдвэрт заана.

10.11.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Компанийн тухай хуулийн 62.1.9-д заасан асуудлыг заавал хэлэлцэнэ.

10.12. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга удирдан явуулна.

10.13. Компанийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчийн саналаар хурлын даргыг сонгох асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож буй саналын эрхтэй гишүүдийн олонхийн саналаар сонгож болно.

10.14. Шаардлагатай тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл саналын эрхийн 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн санаачилгаар ээлжит бус хурлыг "Компанийн тухай" хуульд заасан журмын дагуу зарлан хуралдуулж болно.

10.15. Дор дурьдсан асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

10.15.1. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах

эрхийн бичгийг биет бус үнэт цаасны хэлбэрээр гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид бүртгүүлнэ.

9.13. Хувьцаа худалдах авах тухай эрхийн бичгээ ашиглан хувьцаа худалдаж авах захиалга, Хөрөнгийн биржийн төвлөрсөн хадгаламж дахь компанийн дансанд захиалсан хувьцааны үнийг төлсөн баримт зэргийг зар хүрснээс хойш 15 хоногийн дотор компанид ирүүлээгүй хувьцаа эзэмшигчдийн хувьцаа худалдаж авах эрхийн бичгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр нийтэд арилжаалж болно. Хувьцаа эзэмшигч нь өөрт ногдох хувьцаа худалдаж авах эрхийн бичгээ бүрэн болон хэсэгчилэн бусдад худалдсан бол энэ тухай бичгээр худалдаж авах хувьцааны үнийг төвлөрсөн хадгаламж дахь компанийн дансанд төлсөн байна. Хувьцаа худалдаж авах эрхийн бичгийн хугацаа дуусмагц компанийн Төлөөлөн удирдах зөвлөл түүнийг хүчингүй болгох шийдвэр гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид мэдэгдэж бүртгэлээс хасуулна.

9.14. Компани өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан тодорхой хугацааны тогтоосон хувь төлж, эргүүлэн авах нөхцөлтэйгээр өрийн бичиг гаргах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ. Шийдвэрт гаргах өрийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, нөхцөл, эргэж төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.

9.15. Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно. Опционоор худалдаж авч болох энгийн хувьцаа нь гүйлгээнд байгаа нийт хувьцааны 25 хувиас бага бол опцион гаргах шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс их бол хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана. Шийдвэрт гаргах опционы тоо нэгж опцион эзэмшигчийн худалдан авч болох хувьцааны тоо, хувьцаа худалдаж авах үнэ, опционы хүчинтэй байх хугацаа, опционы үнэ зэргийг заасан байна.

9.16. Компаниас гаргасан хувьцаанд хөрвөх үнэт цаасаар хөрвөх хувьцааны тоо, нийт гаргасан опционоор худалдах хувьцааны тоо, гүйлгээнд гаргасан хувьцааны тоо зэргийн нийлбэр нь нийт зарлагдсан хувьцааны тооноос илүү байж болохгүй.

9.17. Хувьцаа болон бусад үнэт цаасны үнийг "Компанийн тухай" хуулийн 55-р зүйлд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

9.18. Компаниас шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг мөнгө, үнэт цаас, эд хөрөнгийн хэлбэрээр хийж болно. Үнэт цаасны төлбөрт тооцох мөнгөн бус хөрөнгийн үнэлгээг уг хэлцэл хийхийг сонирхогч бус Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд санал нэгтэй тогтооно. Үнэлгээг тогтоохдоо мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэс болгоно.

Шинэчилсэн найруулга 2012 он

10.15.2 Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах

10.15.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох

10.15.4. Компанийг татан буулгах, татан буулгах комиссыг томилох

10.15.5. Хувьцааг хуваах, нэгтгэх

10.15.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох

10.15.7. Хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэх эсэх .

10.15.8. Компанийн жилийн үйл ажиллагааны талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах

10.15.9. Төлөөлөн удирдах зөвлөлөөс хэлэлцүүлэхээр оруулсан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцлийг батлах

10.15.10. Энэ хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа худалдан авахыг зөвшөөрөх

10.15.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоох

10.15.12. Компанийн тухай хуулийн 96.4-т заасан тайланг батлах

10.15.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд

10.16. Нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна.

10.17. Компанийн хурлын бүрэн эрхэд хамаарах бүх асуудлыг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

10.18. Хурлын тухай мэдээллийг нийтэд хүргэх, хуралд оролцох эрхтэй гишүүдийг тодруулах, санал авах ажиллагааг "Компанийн тухай" хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу явуулна.

10.19. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргаж, хурлаар хэлэлцэх асуудлын товыг тогтоосноос хойш хувьцаа эзэмшигчдийн хурлаар яаралтай хэлэлцэж шийдвэрлэх асуудал гаргасан тохиолдолд хуралд

Шинэчилсэн найруулга 2012 он

оролцогчдын саналын олонхиор уг асуудлыг хэлэлцэхээр шийдвэр гаргаж болно.

- 10.20. Компанийн саналын эрхтэй хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Энд заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж дахин хуралдах өдрийг товлож энэ тухай протокол үйлдэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурна. Хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчилж болохгүй.
- 10.21. Саналын эрхийн 50-иас дээш хувийг эзэмшигчид оролцсоноор хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно.
- 10.22. Хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Хойшлогдсон хурал хуралдахаас ажлын 7 ба түүнээс дээш хоногийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.
- 10.23. Хойшлогдсон хуралд бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй.
- 10.24. Хойшлогдсон хурал ажлын 20 хоногийн дотор хуралдаж чадахгүй бол шинэр хурал зарлаж, хурал хүчин төгөлдөр болох ирцийг энэхүү зүйлийн 6.10-т зааснаар тогтооно.
- 10.25. Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Эчнээ санал хураалтыг "Компанийн тухай" хуульд заасан журмын дагуу явуулна. Ээлжит хурлыг болон доорх асуудлыг шийдвэрлэх хурлыг эчнээ санал хураалтаар оруулахыг хориглоно. Үүнд:
- Компанийн дүрмийг өөрчлөх, шинэчилсэн найруулгыг батлах
 - Компанийн нийлүүлэх, нэгтгэх, хуваах, татан буулгах, зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх
- 10.17 Компанийн нийт гаргасан хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь өөрөө эчнээ санал хураалтын дүнг нэгтгэн тооллогын комиссын үйл ажиллагааны ажиглагчаар оролцох эрхтэй.
- 10.18 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг "Компанийн тухай" хуульд заасан журмын дагуу хөтөлж, баталгаажуулан хадгална.

Б. Төлөөлөн удирдах зөвлөл

- 10.19 Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 10.19.1. Энэ дүрэмд заагаагүй үйл ажиллагааны чиглэлийг тогтоох

Шинэчилсэн найруулга 2012 он

- 10.19.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бүртгэлийн өдөр хурлын товыг тогтоох
- 10.19.3. Компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа нэмж гаргах
- 10.19.4. Нэмж гаргах хувьцаа нь энэ дүрэмд заасан их хэмжээний хэлцэлд хамаарах бол хувьцаа нэмж гаргах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 10.19.5. Хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах
- 10.19.6. Компанийн тухай хулийн 55-р зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох
- 10.19.7. Өөрийн гаргасан нийт энгийн хувьцааны 5 хүртэл хувийг болон бусад үнэт цаасыг худалдан авах, эргүүлэн авах
- 10.19.8. Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох
- 10.19.9. Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал урамшууллын хэмжээг тогтоох
- 10.19.10. Компанийн аудиторыг сонгож, түүнтэй хийх гэрээний нөхцлийг тогтоох
- 10.19.11. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах
- 10.19.12. Ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тогтоох
- 10.19.13. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг батлах
- 10.19.14. Компанийн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах
- 10.19.15. Компанийг өөрчлөн байгуулах төсөл боловсруулж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх, шийдвэрийг хэрэгжүүлэх
- 10.19.16. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотойгоос бусад их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох
- 10.19.17. Сонирхолын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох
- 10.19.18. Компаниас тусгаарлах тухай шийдвэр гаргах

Шинэчилсэн найруулга 2012 он

10.19.19. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал

10.20. Энэ дүрмийн 10.19 дэх заалтын 5, 9, 16, 18-д дурьдсан асуудлыг шийдвэрлэхэд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн гэж өөрөө болон эхнэр, нөхөр, эцэг, эх, хүүхэд, төрсөн ах дүү болон нэгдмэл сонирхолтой этгээд нь Төлөөлөн удирдах зөвлөлөөр шийдвэрлэх дээрх асуудлуудад сонирхол бүхий этгээд биш хүнийг тооцно.

10.21. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь (9) гишүүнтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар (4) жилийн хугацаатай сонгоно. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ.

10.22. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс удаан хугацаагаар үүргээ биелүүлж чадахгүй болсон эсхүл нас барсан тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлөөс түр нөхөн томилно.

10.23. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хууль, энэ дүрэмд заасан хугацаанд зарлаагүй бол 5 сарын 1-ний өдрөөр Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх дуусгавар болно.

10.24. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос сонгоно.

10.25. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүрэг хүлээнэ.

10.26. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг жилд 2-доошгүй хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд нэмэлт хуралдаан хийж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр нь тогтоол байх бөгөөд тогтоолд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулна.

10.27. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнхи олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болх бөгөөд хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнхи олонхи саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд гишүүн бүр 1 саналын эрхтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга саналын давуу эрх эдлэхгүй.

В. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо.

Шинэчилсэн найруулга 2012 он

10.28. Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.

10.29. Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

10.30. Төлөөлөн удирдах зөвлөлийн хороо нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, энэ хуульд заасан зарим асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй.

10.31. Энэ дүрмийн 10.29-т заасан аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна:

10.31.1. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

10.31.2. дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;

10.31.3. аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;

10.31.4. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;

10.31.5. компанийн дүрэмд заасан болон төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

10.32. Энэ хуулийн 10.29-т заасан нэр дэвшүүлэх хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.32.1. компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

10.32.2. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд компанийн тухай хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

10.32.3. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн

Шинэчилсэн найруулга 2012 он

сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;

10.32.4. төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

10.32.5. гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;

10.32.6. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

10.32.7. компанийн тухай хуулийн 59.5-д заасан үндэслэлээр төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш гурван жилийн хугацаанд тухайн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байсан этгээдийн нэрийг аливаа хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах.

10.33. Энэ хуулийн 10.29-т заасан цалин, урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна:

10.33.1. компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

10.33.2. төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;

10.33.3. компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх.

Г. Нэр дэвшүүлэх хороо

10.34. Компанийн дүрмийн 10.29 -т заасан нэр дэвшүүлэх хороо нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан хүний нэрийг дэвшүүлнэ:

10.34.1. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;

10.34.2. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй;

Шинэчилсэн найруулга 2012 он

- 10.34.3. төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;
- 10.34.4. компанитай бизнесийн аливаа холбоогүй.

В. Гүйцэтгэх захирал

10.28. Гүйцэтгэх захирал нь энэ дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

10.29. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болно.

10.30. Гүйцэтгэх захирал нь өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад сонгогдон ажиллаж болно. Харин өөр компани, аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагад ажиллахыг хориглоно.

10.31. Гүйцэтгэх захиралын эрх үүрэг, хариуцлагын хэмжээ, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэргийг Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заана.

10.32. Энэ дүрэмд заасан Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах шаардлагатай их хэмжээний хэлцэлээс (Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой түүхий эд, материал, сав баглаа, боодол, сэлбэг хэрэгсэл, түлш шатхуун худаллан авах, бараа бэлэн бүтээгдэхүүн худалдах, үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох хэлцэл үүнд хамаарахгүй) бусад хэлцэл хийх, компанийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах, эрх бүхий албан тушаалтыг ажилд томилох, чөлөөлөх, компанийн орон тоо, цалингийн сангийн хэмжээг тогтоох, компанийн ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг батлах, тэдэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг байгуулах зэрэг компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

Г. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

10.33. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг 4 жилийн хугацаатай компанийн захиргааны ажилтнуудаас Төлөөлөн удирдах зөвлөл сонгож ажиллуулна.

10.34. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга дор дурьдсан үүрэг хүлээнэ:

10.34.1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын шийдвэрээс компанийн гишүүдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын зар түгээж, хурлын хэлэлцэх асуудалтай холбогдох материал тараах;

Шинэчилсэн найруулга 2012 он

10.34.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөл, хянан шалгагчдын зөвлөлийн хурлын ирц гаргаж, протокол хөтлөх

10.34.3. Хурлын материалыг цэгцэлж, холбогдох байгуулгад хувийг хүргүүлэх, хурлын шийдвэрийн биелэлтэнд хяналт тавьж, явцыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад танилцуулж байх

10.34.4. Эрх үүргийнхээ хэмжээнд компанийн захиргаанаас зохих материал, судалгаа шаардаж гаргуулах

10.34.5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөл, хянан шалгах зөвлөлийн хурлуудын шийдвэрийг биелэлтийг хувь нийлүүлэгчдэд мэдээлэх.

10.34.6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хөтлөх

АРВАН НЭГ. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа,

бүртгэл тайлан, ногдол ашгийн хувиарлалт

11.1. Компани нь санхүүгийн жил, жил бүрийн 1-р сарын 1-нээс эхлэж, 12-р сарын 31-нд дуусгавар болно.

11.2. Компани нь санхүүгийн тайлангаа "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль, "Аудитын тухай" хууль болон бусад хуулийн дагуу баталгаажуулан үүний үндсэн дээр татварын багц хуулийн заалтад нийцүүлэн тогтоосон хугацаанд нь татвараа тодорхойлон төлж, татварын тайлан гаргаж тооцоо хийнэ. Санхүүгийн тайланг мөрдөж буй хууль, тогтоомжийн дагуу санхүү, татварын байгууллага, Үнэт цаасны хороо, Хөрөнгийн биржид хуулийн хугацаанд хүргүүлнэ.

11.3. Санхүүгийн тайланд дараах бүрдэл хэсгүүдийг заавал оруулна:

- Баланс
- Орлого, үр дүнгийн тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан
- Хуримтлагдсан ашгийн тайлан
- Тайлангийн тайлбар, тодруулга, илтгэх хуудас

11.4. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг гүйцэтгэх захирал хариуцна. Компанийн орон тоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ерөнхий санхүүч хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

Шинэчилсэн найруулга 2012 он

11.5. Хяналт шалгалт, лавлагаа, түүх архивын зорилгоор дараах баримт бичгүүдийг хуульд заасан хугацаагаар хадгална:

11.5.1 Компанийн дүрэм түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд

11.5.2 Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ

11.5.3. Компанийн дотоод бичиг, баримт, материалууд

11.5.4. Компанийн салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм, гэрээнүүд

11.5.5. Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичгүүд

11.5.6. Компанийн гүйцэтгэх захиралын тушаал, шийдвэр, хурал зөвлөгөөний тэмдэглэл

11.5.7. Санхүү, аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны болон дэлгэрэнгүй бүртгэл, ня-бо бүртгэлийн баримт, бичиг, материалууд

11.5.8 Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцэл түүнтэй холбогдох баримт, материалууд

11.6. Компанийн нягтлан бодох бүртгэлийг хөтлөх нэгж нь төгрөг байх бөгөөд эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн орлого, зарлага, өр, авлагын гүйлгээг тухайн ажил гүйлгээ хийгдсэн валютаар төгрөгт шилжүүлэхдээ тухайн өдрийн Монгол банкны албан ханшийг баримтална.

11.7. Компанийн аж ахуй санхүүгийн үйл ажиллагааг санхүүгийн тайлан, холбогдох анхан шатны нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтэд үндэслэн эрх бүхий татварын болон хөндлөнгийн хяналтын байгууллага шалгах эрхтэй бөгөөд компанийн эрх бүхий албан тушаалтан холбогдох баримт, маягтыг шаардлагын дагуу толилуулах үүрэг хүлээнэ.

11.8. Компани Монгол улсын аль нэг болон хэд хэдэн банкинд төгрөгийн болон валютын данс нээх эрхтэй бөгөөд шинээр данс нээлгэсэн, хаалгасан тухай бүр Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж байна. Компани гадаадын банкинд валютын данс нээх бол энэ тухайгаа Монгол банк болон татварын албанд албан ёсоор мэдэгдэнэ.

11.9. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурьдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна.

11.9.1. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх

Шинэчилсэн найруулга 2012 он

11.9.2. Ногдол ашиг төлсний дараа компани өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх

11.10. Ногдол ашиг хувиарласны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувиарласны өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд ногдол ашгаа шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдэл хэмжээг бичгээр мэдэгдэнэ.

11.11. Ногдол ашиг хуваарилаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөл, үүний шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

11.12. Ногдол ашиг хуваариласны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг Гүйцэтгэх захирал боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар баталж мөрдөнө.

АРВАН ХОЁР. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт


А. Аудиторын хяналт

12.1. Аудитын тухай Монгол улсын хуульд заасны дагуу компанийн санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийх зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас сонгосон эрх бүхий аудитын байгууллагатай гэрээ байгуулан ажиллана.

12.2. Гэрээг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлах бөгөөд гэрээнд аудиторын эрх үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана.

12.3. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна. Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ.

12.4. Ээлжит бус шалгалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, хяналтын зөвлөл болон гүйцэтгэх захирлын шийдвэрээр хэдийд ч хийж болно. Аль нэг хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэнээс бусад шалгалтын хөлсийг компани хариуцаж төлнө. Хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэн шалгалтын хөлсийг тухайн хувьцаа эзэмшигч хариуцаж төлөх бөгөөд шалгалтын явцад эрх



Шинэчилсэн найруулга 2012 он

бүхий албан тушаалтан эсхүл хувьцаа эзэмшигч компани, хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

12.5. Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримтыг танилцуулах үүрэгтэй.

12.6. Дараах этгээдийг компанийн аудиторoor сонгон ажиллуулахыг хориглоно.

12.6.1. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий тушаалтан

12.6.2. Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, компани болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд холбогдох бусад эд хөрөнгөийн эрх эзэмшдэг бол

12.6.3. Компанийн аудитаас бусад асуудлаар гэрээ хэлцэл хийсэн бол

АРВАН ГУРАВ. Компанийг өөрчлөн байгуулах

13.1. Компанийн өөрчлөн байгуулах тухай ойлголтод компанийг хуваах бусад компанитай нийлэх, нэгдэх, тусгаарлах, өөрчлөх асуудлууд хамаарагдана.

13.2. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг "Компанийн тухай" хуулийн 18-24 дүгээр зүйлийн заалтуудыг үндэслэн шийдвэрлэнэ.

АРВАН ДӨРӨВ. Компанийг татан буулгах

14.1. Компанийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгана:

14.1.1. Компаний үйл ажиллагаа алдагдалтай байгаагаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;

14.1.2. Компанийг татан буулгахыг хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхи зөвшөөрсөн;

14.1.3. Хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхи нь компанийг хуваах, өөр компанид нэгдэх шийдвэр гаргасан.

14.2. Монгол улсын шүүх компанийг дор дурьдсан үндэслэлээр татан буулгана.

14.2.1. Дампуурсан;

14.2.2. Нэг ч гишүүн үлдээгүй;

Шинэчилсэн найруулга 2012 он

14.2.3. Хуульд заасан бусад үндэслэл .

14.3. Татан буулгах шийдвэр гаргасан гишүүдийн хурлаас татан буулгах комиссыг томилно. Хурлын дарга татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараагаа компанид үлдэж байгаа эд хөрөнгийн хувь нийлүүлэгчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төсөл, хуваах юмуу нэгдэх шийдвэр гаргасан бол хуваах болон нэгдэх төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

14.4. Татан буулгах комисс томилсноор тухайн компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжих бөгөөд уг комисс нь компанийн нэрийн өмнөөс шүүх хуралд оролцоно.

14.5. Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн компанид, эсхүл зээлдүүлэгчид ямар нэг хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцна.

14.6. Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах хугацаа, журмыг нийтэд болон зээлдүүлэгчдэд мэдээлнэ.

14.7. Нэхэмжлэл гаргах хугацаа дууссан өдрөөр тасалбар болгон компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, зээлдүүлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын дүнг тусгасан татан буулгах түр балансыг гаргах бөгөөд уг балансыг гишүүн хурал батална.

14.8. Татан буулгах комисс нэхэмжлэлийг хэрхэн барагдуулах тухайгаа нэхэмжлэгчдэд бичгээр мэдэгдэнэ.

14.9. Компанийн мөнгөн хөрөнгө нь нэхэмжлэлийг барагдуулахад хүрэлцэхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлын зөвшөөрлөөр компанийн бусад эд хөрөнгийг худалдаж болно. Зээлдүүлэгчдийн өр төлбөрийг барагдуулсны дараа үндсэн эд хөрөнгө, эд хөрөнгө эсхүл тэдгээрийг зээлдүүлэгчдийн өр төлбөрийг барагдуулсны дараа үндсэн эд хөрөнгө, эд хөрөнгө эсхүл тэдгээрийг худалдаж борлуулсан орлогыг хувь нийлүүлэгчдэд тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлж хувиарлана.

14.10. Компанийн эд хөрөнгийг хуваариласны дараа татан буулгах комисс компанийг татан буулгах замаар үйл ажиллагаа дуусгавар болсныг бүртгэх байгууллагад мэдэгдэж, татан буулгах балансын нэг хувийг хүргүүлнэ.

14.11. Компани нэгдэх, өөрчлөн зохион байгуулснаас үйл ажиллагаа нь дуусгавар болж байгаа тохиолдолд бүртгэх байгууллага болон олон нийт, зээлдүүлэгчдэд

Шинэчилсэн найруулга 2012 он

хүргэх мэдэгдэлд компаний эрх үүргийг шилжүүлэх, авсан хуулийн этгээдийн нэрсийг заана.

14.12. Хуваагдсаны улмаас компанийн үйл ажиллагаа дуусгавар болсон бол хуваах балансын дагуу компанийн эрх үүргийг шилжүүлж авсан компани тус бүрийн нэрсийг мэдээлнэ.

14.13. Бүртгэх байгууллага компанийг улсын бүртгэлээс хассанаар буугдсанд тооцно.

АРВАН ТАВ. Дүрэм хүчин төгөлдөр болох

1. Энэ дүрмийг монгол хэлээр 3 хувь үйлдэж, нотариатаар гэрчлүүлэн, нэг хувийг нотариатад, нэг хувийг УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт, нэг хувийг компани өөртөө хадгална.
2. Энэхүү дүрэм нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлагдаж, УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөс хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

